



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” ХНН-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2025 он

**“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” ХНН-ИЙН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**
(жилийн эцсийн байдлаар)

2026.01.09

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Улаанбаатар төмөр зам” /УБТЗ/ хувь нийлүүлсэн нийгэмлэг /ХНН/-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“УБТЗ” ХНН-ийн 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 81.9%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
1	-	-	1	-	30.0%

2.2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
52	42	10	-	-	93.5%

2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
16	13	2	-	-	1	93.3

2.4. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
34	32	1	-	1	-	95.4%

2.5. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
7	7	-	-	-	-	100.0%

2.6. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	87.2
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	94.0
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	87.5
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	95.8
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	91.0
Дүн		90.1

2.7. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Үүнээс:			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаандаа	Хоцорсон	Мэдээлээгүй	
62	62	62	-	-	100.0

Гурав. Үнэлэлт, дүгнэлт
Төлөвлөлтийн байдал:

“УБТЗ” ХНН-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /2.2, 2.20, 8.2, 8.3/

Хэрэгжилтийн байдал:

1) “УБТЗ” ХНН-ийн 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 81.9%-тай байна.

2) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Эрэнцав–Чойбалсан чиглэлийн 238 км төмөр замын их засварын ажлын санхүүжилт шийдвэрлэгдээгүйтэй холбоотойгоор хэрэгжилт хангалтгүй байна.

3) 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 52 арга хэмжээний хэрэгжилт 93.5% байна. Үүнээс 80.8% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 19.2% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

4) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Зорилтот түвшин	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. УБТЗ-ын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	<i>Жилийн эцсийн байдлаар:</i> 33.5 сая.тн. ачаа, 2.5 сая зорчигч тээвэрлэнэ.	95.7
Зорилт 2. Төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх чадвар, хөдлөх бүрэлдэхүүний засварын баазын хүчин чадлыг сайжруулна.	-34 км гол замд их засвар хийж, -12 бетон хоолойгоор тоноглоно. -2 технологи шинээр эзэмшинэ. -62 вагонд их засвар хийнэ.	90.5
Зорилт 3. Компанийн засаглалыг сайжруулж удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.	-Хөндлөнгийн аудитад тэнцсэн байна -Дотоод аудит хийгдсэн байна	92.5
Зорилт 4. Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгож хяналтыг сайжруулна.	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн жилийн зорилтын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна	100.0
Зорилт 5. Цахим шилжилтийг эрчимжүүлж мэдээллийн технологийг хөгжүүлнэ.	-4 систем хөгжүүлэлт, -1 аппликейшн хөгжүүлэлт хийгдсэн байна.	100.0
Зорилт 6. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж хуулийн хэрэгжилтийг хангуулна.	-Сургалтад холбогдох албан хаагчдыг 100 хувь хамруулна.	100.0
Зорилт 7. Хүний нөөц, нийгмийн салбарын бодлого зохицуулалтын хэрэгжилтийг хангана.	-Хөтөлбөрүүдэд нийт 5345 төмөр замчин, оюутан хамрагдана -Өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.	96.2
Зорилт 8. Салбарын эрх зүйн орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Төмөр замын тээврийн дүрэм, журмын төсөл боловсруулах, батлуулахад оролцоно.	85.0

5) “УБТЗ” ХНН нь 2025 онд 33,727 сая тонн ачаа, 1,753 сая зорчигч тээвэрлэж, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас 1430,1 тэрбум төгрөгийн орлого олсон бөгөөд үүнээс 44 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан төмөр замын дэд бүтцийн нэвтрүүлэх хүчин

чадлыг сайжруулах зорилгоор төлөвлөсөн гол замын их засварын ажлыг бүрэн гүйцэтгэж, нийт 34.6 км замд их засвар хийсэн байна.

6) “УБТЗ” ХНН-ийн 2025 оны II улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн 6 зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

- Жилийн хугацаанд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулахдаа арга хэмжээгээ оновчтой тодорхойлон, хэрэгцээ шаардлагад нийцсэн, судалгаанд тулгуурласан арга хэмжээ төлөвлөж, цаашид ижил төрлийн алдаа гаргахгүй байх; /Оорцог-Энгэр зөрлөгийн зам сумын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх/

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төрийн үйл ажиллагааг нээлттэй, хүртээмжтэй, хүнд сурталгүй, авлигаас ангид байлган, нийгэмлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн, бүрэн байршуулах;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Эрэнцав-Чойбалсан чиглэлийн 238 км төмөр замын их засвар хийх ажлын судалгааг дуусгаж, барилгын ажлыг эхлүүлэх;

2. Монгол–Орос–Хятадын эдийн засгийн коридорын Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-ийг нэгтгэж, баталгаажуулах ажлыг яаравчлах;

3. Толгойт-Амгалан хооронд 48 шөрмөсний шилэн кабель суурилуулах ажлын дутуу үлдсэн 50 хувийг 2026 онд бүрэн гүйцэтгэж дуусгах;

4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дагуу өгсөн үүрэг даалгаврын хүрээнд тус нийгэмлэгийн ачаа болон зорчигч тээвэрлэлтийн тарифыг зах зээлийн зарчимд нийцүүлэн нэмэгдүүлэх, мөн 2020–2025 оны дунд хугацааны тарифын бодлогын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд уг бодлогод өөрчлөлт оруулах асуудлыг тус нийгэмлэгийн Ерөнхий хороогоор хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төрийн үйл ажиллагааг нээлттэй, нийгэмлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн, бүрэн байршуулах;

6. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан, уг төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт, материалын хамт бүрэн тайлагнадаг тогтолцоог хэвшүүлэх;

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” ХНН-ИЙН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**
(жилийн эцсийн байдлаар)

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	1	1	30.0	20
2	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	52	52	93.5	20
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	16	15	93.3	20
4	Сайдын тушаалын хэрэгжилт	34	33	95.4	10
5	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	7	7	100.0	10
6	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	42	42	90.1	10
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	62	62	100.0	10
Нийт		214	212	81.9	